



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Г
хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Номин даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Номин даатгал” ХХК /И.Галбуян/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 дугаар сарын 29 өдрийн
253 тоот тогтоолын хавсралт



“НОМИН ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

(төгрөгөөр)

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 35,000,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцаан ы тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 40,000,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Ш.Баярсайхан УУ69090814	100	3,500,000,000.00	100%	-	20,000,000.00	87	3,480,000,000.00	69.6%
2	Номин холдинг ХХК 2708892	0	-	-	1,520,000,000.00	-	38	1,520,000,000.00	30.4%
	Нийт	100	3,500,000,000.00	100%		1,500,000,000.00	125	5,000,000,000.00	100%

Тайлбар: Нэгж хувьцааны үнэлгээ 35,000,000 /гучин таван сая/ төгрөг байсан бол 40,000,000 /дөчин сая/ төгрөг болж өөрчлөгдсөн.